



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/34

Арвайхээр

Хүүхдийн эрхийн хууль зүйн
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/190, А/280 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг хорооны гишүүдэд, журмын дагуу заасан хугацаанд холбогдох байгууллагуудад үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг Хууль зүйн хорооны нарийн бичгийн дарга бөгөөд аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ж.Энх-Амар)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 05 сарын 18-ны өдрийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулах тухай” А/237 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0069

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн
хавсралт



Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн

- Дарга: Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Гишүүд:
- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
 - Аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга
 - Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
 - Аймгийн Хүүхдийн элч
 - Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан
 - Өмгөөлөгчдийн холбооны Өвөрхангай аймаг дахь салбар зохицуулагч, өмгөөлөгч
 - Аймагт гэр бүл, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын төлөөлөл